

# Есүс Христэд төгөлдөржих нь

Дараах судрын хэсгүүдийг унш. Төгс бус байдлыг даван туулж, Аврагчтай илүү адилхан болоход Тэр тусалж чадна гэдэгт итгэх итгэлийг тань нэмэгдүүлэх үг хэллэгүүдийг хайж ол. Та хайж олсон зүйлсээ судлах тэмдэглэлдээ эсвэл тараах материалынхаа ар талд жагсааж болно.

Сургаал ба Гэрээнүүд 76:40–42

Ифер 12:27

Моронай 10:32–33

Дараах мэдэгдлийг унш. Төгс байх үзлийг даван туулахын тулд бидний хийж чадах зүйлийг хайж, Есүс Христээр дамжуулан илүү сайн болоход анхаарлаа төвлөрүүл. Та өөрт онцгой санагдсан хэллэгүүдийг тодруулан тэмдэглэж болно.

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дийтр Ф.Угдорф Их Эзэн биднээс юуг хүлээдэг болон хүлээдэггүй талаар ийн заасан.



Бурханд дутагдалгүй хүн хэрэггүй. Тэрээр “зүрх сэтгэл хийгээд эрмэлзэгч оюун” [Сургаал ба Гэрээнүүд 64:34]-аа өргөх хүмүүсийг эрэлхийлдэг бөгөөд тэднийг “Христэд төгөлдөржүүлэх” болно [Моронай 10:32–33]” хэмээн хэлсэн. (Дийтр Ф.Угдорф, “Five Messages That All of God’s Children Need to Hear” [Бригам Янгийн Их Сургуулийн боловсролд зориулсан долоо хоногийн онцгой цугларалт, 2021 оны 8-р сарын 17], 3, [speeches.byu.edu](https://speeches.byu.edu))

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон өөрсдийн төгс бус байдлыг олж харвал юу хийж болох талаар ийн тайлбарлав.



Өдөр бүр хамгийн сайнаараа хийж, сайжрахаар хичээцгээе. Бид өөрсдөөсөө алдаа дутагдал олж харсан үедээ тэдгээрийг засахаар хичээж чадна. Бид өөрсдөдөө болон хайртай хүмүүстээ байдаг алдаа дутагдалд илүү уучламтгай хандаж чадна. (Рассэлл М. Нэлсон, “Perfection Pending,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 88)